



2020 оны 03 дугаар сарын 18  
№11 /1113/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол**

**Журам шинэчлэн батлах  
тухай**

**Монгол Улсын  
олон улсын  
гэрээ**

**Хүчээр алга болгохоос  
бүх хүнийг хамгаалах тухай  
олон улсын конвенц**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

139. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 329 673

### МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

140. Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц 680

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Дугаар 329 Улаанбаатар хот

#### Журам шинэчлэн батлах тухай

Хүнсний тухай хуулийн 6.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам батлах тухай” Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 77 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**Ч.УЛААН**



Засгийн газрын 2019 оны  
329 дүгээр тогтоолын хавсралт

## **СТРАТЕГИЙН ХҮНСИЙГ ЭКСПОРТЛОХ, ИМПОРТЛОХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүнсний тухай хуулийн 3.1.6-д заасан стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрлийг энэ журмын 5.1-д зааснаас бусад тохиолдолд сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгох, стратегийн хүнсийг экспортлох, импортлохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Стратегийн хүнсний нэр төрөл, онцлогоос хамааруулан дараах стратегийн хүнсийг дор дурдсанаар ойлгоно:

1.2.1. “сүү” гэж шингэн болон хуурай сүүг;

1.2.2. “малын мах” гэж үхэр, адуу, тэмээ, хонь, ямааны дулааны аргаар боловсруулсан, шинэ хөргөсөн, эсхүл хөлдүү махыг;

1.2.3. “гурил” гэж улаан буудайн гурилыг;

1.2.4. “ундны ус” гэж хүнсний зориулалтаар савласан усыг;

1.2.5. “тарианы үр” гэж улаанбуудайн үрийг.

Хоёр. Экспортлох, импортлох стратегийн хүнсний  
нэр төрөл, тоо хэмжээг тогтоох

2.1. Тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг стратегийн хүнсний улсын хэмжээний нийт нөөц, хөдөө аж ахуйн болон хүнсний үйлдвэрлэлийн хэмжээ, эрэлт, нийлүүлэлт, үнийн хэлбэлзэл, бусад улс, бүс нутаг, хөрш орны хүнсний хангамж, тэдгээрийн дотоодын зах зээлд нөлөөлөх төлөв байдал, цаашдын таамаглал, бусад оронтой байгуулсан гэрээ, хэлэлцээрийн шаардлага, хүнс экспортлох стратегийн зорилт зэргийг харгалзан Хүнсний тухай хуулийн 6.7-д заасны дагуу тогтооно.

2.2. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “яам” гэх) тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл (цаашид “Үндэсний зөвлөл” гэх)-д хүргүүлнэ. Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор яамнаас Үндэсний зөвлөлд нэмэлт санал оруулж болно.

2.3. Үндэсний зөвлөл энэ журмын 2.2-т заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор хэлэлцэж зөвлөмж гаргана.

2.4. Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 2.3-т заасан зөвлөмжийг үндэслэн тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг БТКУС-ийн кодоод нийцүүлэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор түүхий эд, бүтээгдэхүүн тус бүрээр тогтооно.

2.5. Тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоосон шийдвэрийг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээс хойш ажлын 3 хоногт багтаан яамны цахим хуудаст байршуулна.

Гурав. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт

3.1. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох үйл ажиллагааг нэг цонхны бодлогоор зохион байгуулахаар хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэснээс бусад тохиолдолд стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр яам зохион байгуулна.

3.2. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Ажлын хэсгийг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгуулах бөгөөд Ажлын хэсэг ил тод, шударга байх зарчмыг баримтална.

3.3. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрлийг энэ журмын 3.6-д заасан шаардлагыг хангасан Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно.

3.4. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын зар гаргах, урилга хүргэх, үр дүнг мэдээлэх, оролцогч гомдол гаргах, хариу илгээх ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулна.

3.5. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын зарыг яамны цахим хуудаст байршуулах бөгөөд уг зард энэ журмын 2.4-т заасан нэр төрөл, тоо хэмжээнд багтаан экспортлох, импортлох тоо хэмжээг түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрээр тусгана.

3.6. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн хуулийн этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлж яаманд ирүүлнэ:

3.6.1. импортлох, эсхүл экспортлох хүнсний нэр төрөл, багцын хэмжээг заасан албан бичиг;



3.6.2. хуулийн этгээдийн нэр, байршил, утас, цахим хаяг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, эрхэлж байгаа хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр;

3.6.3. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.21-д заасан хэрэглэгчийн системтэй тухай болон татварын өргүй болохыг нотолсон харьяалах Татварын албаны тодорхойлолт;

3.6.4. аудитаар баталгаажсан сүүлийн жилийн санхүүгийн тайлангийн хуулбар;

3.6.5. хуулийн этгээдийг төлөөлөн сонгон шалгаруулалтад оролцох этгээдэд итгэмжлэл олгосон эрх бүхий албан тушаалтны шийдвэр;

3.6.6. стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрийн байртай болохыг нотолсон мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт;

3.6.7. экспортлогч улсын үйлдвэр, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;

3.6.8. шаардлагатай тохиолдолд импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн албаны эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн байх;

3.6.9. хүн амын хүнсний хангамжийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд яамтай бодлогын гэрээ байгуулахад татгалзах зүйлгүй талаар мэдэгдсэн албан бичиг.

3.7. Энэ журмын 3.6-д заасан материал хүлээн авах эцсийн хугацааг цахим зар гаргасан өдрөөс эхлэн тооцож, ажлын 10 хоногоор тогтооно.

3.8. Ажлын хэсэг хуулийн этгээдийн ирүүлсэн материалыг цахим зард заасан байршил, газарт оролцогчдыг байлцуулан материал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дараа нээнэ.

3.9. Ажлын хэсэг хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй бөгөөд дутуу материалыг нөхөн бүрдүүлэхгүй. Хуулийн этгээдийн тамга, тэмдэггүй, гарын үсэг зурагдаагүй, он, сар, өдөр тодорхойгүй, гаргацгүй, харагдахгүй байдалтай ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.

3.10. Ажлын хэсэг нь хуулийн этгээдийн зөвшөөрөл авахаар хүссэн тоо хэмжээ болон холбогдох бусад материалыг судалж, уг хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох тоо хэмжээг тогтооно.

3.11. Ажлын хэсэг хуулийн этгээдээс ирүүлсэн материалтай холбоотой асуудлаар тайлбар, нэмэлт баримтыг сонгон шалгаруулалтад оролцогчоос шаардаж болно.

3.12. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг энэ журмын 3.8-д заасан хугацаанаас хойш ажлын 5 хоногт багтаан явуулж, сонгон шалгаруулалтын үр дүнг яамны Төрийн нарийн бичгийн даргад танилцуулна. Шаардлагатай тохиолдолд хугацааг 14 хоногоор сунгаж болно. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын дүнг яамны Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсны дараа сонгон шалгаруулалтад тэнцсэн хуулийн этгээдэд импортлох, эсхүл экспортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээ бүхий зөвшөөрөл олгох тухай мэдэгдэл хүргүүлнэ. Сонгон шалгаруулалтад тэнцээгүй хуулийн этгээдэд шалгараагүй үндэслэлийг зааж хариу хүргүүлнэ. Мэдэгдэл болон хариуг албан бичгээр болон цахим хэлбэрээр явуулна.

3.13. Энэ журмын 3.12-т заасан мэдэгдэл болон хариуг оролцогч хуулийн этгээд хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлоо энэ тухай мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын 1 хоногт хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд албан бичгээр гарган цахимаар хүргүүлж болно.

3.14. Оролцогч хуулийн этгээдийн ирүүлсэн гомдлыг ажлын 3 хоногт багтаан хянан үзэж хариуг албан бичгээр болон цахим хаягаар хүргүүлнэ.

3.15. Оролцогч хуулийн этгээдээс энэ журмын 3.14-т заасан хугацаанд гомдол ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн гомдлыг хянан үзээд үндэслэлгүй гэж үзвэл яамны Төрийн нарийн бичгийн дарга шалгарсан хуулийн этгээдэд ажлын 5 хоногт багтаан зөвшөөрөл олгох шийдвэр гаргана.

3.16. Яам стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгохдоо зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 10 хүртэл хувьд тухайн стратегийн хүнсийг дотоодын зах зээлд нийлүүлэх, импортлох зөвшөөрлийг олгохдоо зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 50 хүртэл хувьд тухайн стратегийн хүнсийг дотоодын зах зээлээс худалдан авах шаардлагыг тавьж хуулийн этгээдтэй бодлогын гэрээ байгуулж болно.

3.17. Хуулийн этгээдийн энэ журмын 3.6-д заасны дагуу ирүүлсэн материал болон нэмж ирүүлсэн тайлбар, баримтыг архивын нэгж болгон хадгална.

3.18. Стратегийн хүнс экспортлох, импортлох зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн жагсаалтыг яамны цахим хуудаст байршуулж, хүнсний хяналт хэрэгжүүлэх болон гаалийн байгууллагад хүргүүлнэ.



3.19. Ажлын хэсэг шаардлагатай бол стратегийн хүнсийг экспортлох, импортлох хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санхүү болон бусад үйл ажиллагаанд үнэлгээ хийж, нэг хуулийн этгээдэд өгч болох тоо хэмжээний зөвшөөрлийн дээд хэмжээг тогтоож болно.

3.20. Шалгарсан хуулийн этгээд энэ журмын 3.12-т заасан мэдэгдэлд дурдсан тоо хэмжээг өсгөж, бууруулах эрхгүй.

3.21. Яам нь стратегийн хүнсийг экспортлох, импортлох үйл ажиллагааг нэг цонхны бодлогоор зохион байгуулах арга хэмжээ авч болно.

3.22. Энэ журмын 3.21-д заасан нэг цонхны бодлогыг дараах этгээдтэй хамтран хэрэгжүүлнэ:

3.22.1. барааны гэрчлэх тэмдэг эзэмшигч салбарын төрийн бус байгууллага;

3.22.2. экспорт, импортын эрх бүхий хуулийн этгээдүүд хамтран байгуулсан нэгдэл;

3.22.3. төрийн өмчит хуулийн этгээд.

3.23. Энэ журмын 3.22-т заасан нэг цонхны бодлогыг хэрэгжүүлэх байгууллага нь стратегийн хүнс экспортлох, импортлох зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, хамтран ажиллана. Гэрээний загварыг гадаад худалдааны болон хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

Дөрөв. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох

4.1. Энэ журмын 3.12-т заасан зөвшөөрөл олгох мэдэгдэл авснаас хойш 6 сарын дотор хуулийн этгээд зөвшөөрөлтэй стратегийн хүнсийг экспортолж, импортолно. Энэ хугацаа нь тухайн жилд хүчинтэй байна.

4.2 Хүн амын хүнсний хангамж, үнийн түвшинг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд яамнаас стратегийн хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээний хязгаар, тухайн жилийн мал төллөх болон ургац хураах цаг хугацаанд стратегийн хүнсийг экспортлохгүй, импортлохгүй байх зохицуулалтыг хийж болно.

4.3. Хуулийн этгээд энэ журмын 4.1-д заасан хугацааны дотор стратегийн хүнсийг экспортлоогүй, импортлоогүй тохиолдолд яам зөвшөөрлийг хүчингүй болгож энэ тухай цахим мэдэгдлийг тухайн хуулийн этгээдэд хүргүүлэн гаалийн болон хүнсний хяналт хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

4.4. Энэ журмын 4.3-т заасны дагуу хүчингүй болгосон зөвшөөрөлд заасан тоо хэмжээнд ногдох стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрлийг мөн журмын дагуу дахин сонгон шалгаруулалт явуулсны үндсэн дээр олгоно.

4.5. Хуулийн этгээд зөвшөөрлийг бусдад дамжуулах, шилжүүлэх, худалдахыг хориглоно.

4.6. Гаалийн байгууллага нь улсын хилээр нэвтрүүлсэн стратегийн хүнсний экспорт, импортын мэдээг хуулийн этгээдийн нэр, экспортолсон, импортолсон хүнсний тоо хэмжээг нэвтэрсэн хилийн боомтын нэр тус бүрээр гарган, жил бүрийн 7 дугаар сар, дараа оны 1 дүгээр сард тус тус багтаан яаманд хүргүүлнэ.

4.7. Мэргэжлийн хяналтын байгууллага нь гадаад худалдааны түнш орны хорио цээрийн байгууллагын хянан магадлагаанд хамрагдаж, зохих зөвшөөрөл авсан дотоод, гадаадын үйлдвэрийн талаарх мэдээг яаманд тухай бүр ирүүлнэ.

Тав. Стратегийн хүнсийг онцгой нөхцөлд  
экспортлох, импортлох

5.1. Дараах онцгой нөхцөл үүссэн тохиолдолд стратегийн хүнсийг нэг удаагийн зөвшөөрлөөр экспортлох, импортлох болно:

5.1.1. зах зээлд шинээр нэвтрэх, бүтээгдэхүүний дээж хүргүүлэх, туршилтын ачилт хийх;

5.1.2. Үндэсний зөвлөл энэ журмын 2.3-т заасан хугацаанд тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаар зөвлөмж гаргаагүй.

5.2. Стратегийн хүнсийг нэг удаагийн зөвшөөрлөөр экспортлох, импортлох хуулийн этгээд энэ журмын 3.6.1-3.6.9-д заасан бичиг баримтыг бүрдүүлж яаманд хүргүүлнэ.

5.3. Стратегийн хүнсийг нэг удаа экспортлох, импортлох шийдвэрийг энэ журмын 3.1-д заасан яамны Ажлын хэсгийн шийдвэрийг үндэслэн яамны Төрийн нарийн бичгийн дарга гаргана.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.





## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### 1<sup>1</sup>ХҮЧЭЭР АЛГА БОЛГОХООС БҮХ ХҮНИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ

Энэхүү конвенцид оролцогч улсууд,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд заасны дагуу улсууд хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэх болон дагаж мөрдөх явдлыг хөхиүлэн дэмжих үүрэгтэй гэдгийг анхааралдаа авч,

Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг удирдлага болгон,

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүй, олон улсын эрүүгийн эрх зүйн салбар дахь олон улсын холбогдох гэрээг эш үндэс болгож,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1992 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 47/133 тоот тогтоолоор батласан Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай тунхаглалыг мөн эш үндэс болгож,

хүчээр алга болгох нь онц ноцтой гэмт хэрэг, тодорхой нөхцөл байдалд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэж олон улсын эрх зүйгээр тодорхойлсныг ухамсарлаж,

хүчээр алга болгохыг таслан зогсоох, хүчээр алга болгох гэмт хэрэг үйлдсэн үед түүнийг шийтгэлгүй үлдээх явдалтай тэмцэл хийх шийдвэр төгс байж,

хүчээр алга болгох явдалд өртөхгүй байх нь хүн бүрийн эрх бөгөөд хохирогчдыг шударга шүүхээр хамгаалуулах, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг ухамсарлаж,

хүчээр алга болсон нөхцөл байдал, алга болсон хүний талаар үнэнийг мэдэх хохирогчийн эрх, түүнчлэн эл зорилгоор мэдээллийг чөлөөтэй цуглуулах, олж авах, түгээх эрхийг нотолж, дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

#### I ХЭСЭГ

##### 1 дүгээр зүйл

1. Хэнийг ч хүчээр алга болгож үл болно.

<sup>1</sup> Уг конвенцыг УИХ-аас 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдөр соёрхон баталсан.



2. Ямар ч онцгой тохиолдол, дайны байдал буюу дайны аюул учирсан, дотоод улс төрийн тогтворгүй байдал, эсхүл бусад онцгой нөхцөл байдалд байлаа ч гэсэн хүчээр алга болгох явдлыг зөвтгөх үндэслэл болохгүй.

### **2 дугаар зүйл**

Энэхүү конвенцын зорилгод “хүчээр алга болгох” гэдэг нь алга болсон аливаа хүний эрх чөлөөг хассан явдлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан буюу түүний хувь заяаны талаарх мэдээлэл, эсхүл оршин суугаа газрыг нуусны улмаас тухайн хүнийг хуулийн хамгаалалт эдэлж чадахааргүй байдалд хүргэхүйцээр төрийн төлөөлөгчид буюу төрөөс эрх олгогдсон, дэмжлэг буюу зөвшөөрөл авсан этгээдүүд, эсхүл бүлэг этгээдийн тухайн хүнийг баривчлах, саатуулах, хулгайлах, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасахыг хэлнэ.

### **3 дугаар зүйл**

Оролцогч улс бүр төрөөс эрх олгогдоогүй, дэмжлэг буюу зөвшөөрөл аваагүй этгээдүүд буюу бүлэг этгээд 2 дугаар зүйлд заасан үйлдлийг хийсэн бол тэднийг мөрдөн байцаах болон уг этгээдийг харъяалах шүүхийн байгууллагад шилжүүлэх талаар холбогдох бүхий л арга хэмжээ авна.

### **4 дүгээр зүйл**

Оролцогч улс бүр хүчээр алга болгохыг гэмт хэрэг гэж үзэн эрүүгийн хуульдаа тусгах талаар шаардлагатай бүхий л арга хэмжээ авна.

### **5 дугаар зүйл**

Хүчээр алга болгох түгээмэл дэлгэрсэн буюу тогтолцоо бүхий дадлыг олон улсын одоо хэрэглэж буй эрх зүйд тодорхойлсноор хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэж үзэх бөгөөд түүний үр дагаврыг олон улсын одоо хэрэглэж буй эрх зүйн дагуу шийдвэрлэнэ.

### **6 дугаар зүйл**

1. Оролцогч улс бүр наад зах нь дараах этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулах зорилгоор шаардлагатай арга хэмжээ авна:

(а) хүчээр алга болгох үйлдлийг гүйцэтгэсэн, түүнийг гүйцэтгэхийг тушаасан, турхирсан буюу өдөөсөн, гүйцэтгэхийг сэдсэн, түүнд оролцсон буюу хамтарч гүйцэтгэсэн аливаа этгээд;



(b) дарга нь, хэрэв:

- i) түүний хяналт, удирдлаган дор бодитойгоор харьяаллагддаг ажилтан нь хүчээр алга болгох гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэхээр завдсан гэдгийг мэдэж байсан, эсхүл энэ талаарх тодорхой мэдээллийг санаатайгаар үл тоомсорлосон бол;
- ii) хүчээр алга болгох гэмт хэрэгтэй холбоотой үйл ажиллагааны хувьд бодит хариуцлага хүлээж байсан, эсхүл бодит хяналт тавьж байсан бол;
- iii) хүчээр алга болгох үйлдлийг өөрийн эрх мэдлийн хүрээнд таслан зогсоох буюу түүнээс урьдчилан сэргийлэх, эсхүл мөрдөн байцаалт буюу эрүүгийн мөрдөн мөшгөлт хийлгэхээр уг асуудлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх талаар бүхий л шаардлагатай болон боломжит арга хэмжээ аваагүй бол.

(c) дээр дурдсан (b) дэд хэсгийг цэргийн дарга буюу цэргийн даргын чиг үүргийг бодитоор хэрэгжүүлж буй этгээдийн хувьд олон улсын эрх зүйд хэрэглэгдэх хариуцлагын талаарх илүү хатуу хэм хэмжээнд нөлөөлөхгүйгээр хэрэглэнэ.

2. Төр, иргэн, цэргийн буюу бусад байгууллагаас гаргах ямар ч тушаал, шийдвэр нь хүчээр алга болгох гэмт хэргийг зөвтгөх үндэслэл болохгүй.

### **7 дугаар зүйл**

1. Оролцогч улс бүр хүчээр алга болгох гэмт хэргийн онц ноцтой шинжийг харгалзан зохих шийтгэл ногдуулна.

2. Оролцогч улс бүр:

(a) хүчээр алга болгох гэмт хэрэгт холбоотой боловч алга болсон этгээдийг амьдаар нь буцаахад бодит туслалцаа үзүүлсэн, эсхүл хүчээр алга болгох нөхцөл байдлыг тогтооход буюу хүчээр алга болгох үйлдлийг гүйцэтгэсэн этгээдийг таньж тогтооход дэмжлэг үзүүлсэн аливаа этгээдийн хувьд түүнд ногдуулах хариуцлагыг хөнгөрүүлж болно;

(b) ялангуяа алга болсон этгээд нас барсан, эсхүл хүчээр алга болгох үйлдлийг жирэмсэн эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүн, тахир дутуу буюу бусад эмзэг бүлгийн хүмүүсийн эсрэг үйлдсэн бол ногдуулах хариуцлагыг эрүүгийн эрхийн бусад журмыг хөндөхгүйгээр хүндрүүлж болно.

### **8 дугаар зүйл**

5 дугаар зүйлийг хөндөхгүйгээр,

1. Хүчээр алга болгох үйлдлийн хувьд хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тогтоох оролцогч улс бүр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хөөн хэлэлцэх хугацааны талаар дараах шаардлагатай арга хэмжээ авна:

(а) хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн гэмт хэргийн онц ноцтой байдалтай дүйцэж үргэлжилнэ;

(б) хүчээр алга болгох гэмт хэрэг үйлдэгдэж дууссаны дараа түүний үргэлжилсэн байдлыг харгалзсаны үндсэн дээр хөөн хэлэлцэх хугацааг тоолж эхэлнэ.

2. Оролцогч улс бүр хүчээр алга болгох гэмт хэргийн хохирогчдыг хөөн хэлэлцэх хугацааны туршид үр дүнтэй эрх зүйн хамгаалалтаар хангах эрхийн баталгаа гаргана.

### **9 дүгээр зүйл**

1. Оролцогч улс бүр хүчээр алга болгох гэмт хэргийн хувьд дараах тохиолдолд хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх өөрийн эрх мэдлийг тогтоох талаар шаардлагатай арга хэмжээ авна:

(а) гэмт хэргийг түүний хэргийн харьяалалд хамаарах нутаг дэвсгэр, эсхүл тухайн улсад бүртгэлтэй агаарын хөлгийн бүхээгт буюу хөлөг онгоцны тавцан дээр үйлдсэн бол;

(б) сэжигтэн этгээд тухайн улсын иргэн бол;

(с) алга болсон этгээд тухайн улсын иргэн нь бөгөөд хэрэв тухайн улс үүнийг шаардлагатай гэж үзсэн бол.

2. Оролцогч улс бүр түүний хэргийн харьяалалд хамаарах нутаг дэвсгэрт байгаа сэжигтэн этгээдийг олон улсын эрх зүйн өөрийн хүлээсэн үүргийн дагуу аль нэг өөр улсад өгөөгүй буюу шилжүүлээгүй, эсхүл хэргийн харьяаллыг нь хүлээн зөвшөөрдөг олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлээгүй бол тухайн улс хүчээр алга болгох гэмт хэргийн хувьд хэргийн харьяаллаа хэрэгжүүлэх өөрийн эрх мэдлийг тогтоох талаар мөн шаардлагатай арга хэмжээ авна.

3. Энэхүү конвенц нь дотоодын эрх зүйн дагуу хэрэгжүүлэх эрүүгийн хэргийн ямар ч нэмэлт харьяаллыг үгүйсгэхгүй.

### **10 дугаар зүйл**

1. Хүчээр алга болгох гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж буй этгээд нутаг дэвсгэрт нь байгаа оролцогч улс бүр өөрийн мэдэлд байгаа мэдээллийг шалгаж үзсэний үндсэн дээр нөхцөл байдал шаардаж байна гэж үзвэл тухайн этгээдийг хорьж саатуулах буюу түүнийг алдахгүй байлгах талаар эрх зүйн бусад бүх арга хэмжээ авна. Ийнхүү хорьж саатуулах буюу авах эрх зүйн бусад арга хэмжээг оролцогч энэ улсын хууль тогтоомжийн дагуу



авах бөгөөд эрүүгийн байцаан шийтгэх үйл ажиллагаатай холбогдуулан түүнийг байлцуулах буюу өгөх, шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацааны туршид л авна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээ авсан оролцогч улс баримт тогтоохын тулд урьдчилсан шалгалт буюу мөрдөн байцаалтыг явуулна. Тухайн улс энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу авсан арга хэмжээ, түүний дотор хорьж саатуулсан тухай, хорьж саатуулах болсон нөхцөл байдлын тухай, урьдчилсан байцаалт буюу мөрдөн байцаалт явуулсны дүнд хийсэн дүгнэлтийн талаар 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан улсад мэдээлэх бөгөөд өөрийн хэргийн харьяаллыг хэрэгжүүлэх чиг санаатай эсэхээ мөн мэдэгдэнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хорьж саатуулагдсан этгээд өөрийг нь харьяалах улсын хамгийн ойр байх бүрэн эрхт төлөөлөгчтэй, хэрэв тэрбээр харьяалалгүй этгээд бол ердийн оршин суугаа улсын төлөөлөгчтэй нэн даруй холбоо тогтоож болно.

### **11 дүгээр зүйл**

1. Сэжигтэн этгээдийг хэргийн харьяалалдаа хамаарах нутаг дэвсгэртээ олж тогтоосон оролцогч улс олон улсын эрх зүйн өөрийн хүлээсэн үүргийн дагуу аль нэг өөр улсад түүнийг өгөөгүй буюу шилжүүлээгүй, эсхүл хэргийн харьяаллыг нь хүлээн зөвшөөрдөг олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлээгүй бол тухайн улс эрүүгийн мөрдөн байцаалт хийлгэхээр өөрийн эрх бүхий байгууллагад уг хэргийг шилжүүлнэ.

2. Эдгээр байгууллага оролцогч тухайн улсын хууль тогтоомжид заасны дагуу эрүүгийн ердийн аливаа хүнд гэмт хэрэг шийдвэрлэдгийн адил шийдвэрээ гаргана. 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу эрүүгийн мөрдөн байцаалт, шийтгэл ногдуулахад шаардлагатай нотлох баримтын талаарх дүрэм журам нь аль ч тохиолдолд 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хэрэглэгдэх нотлох баримтын талаарх дүрэм журмаас илүү хатуу байж болохгүй.

3. Хүчээр алга болгох гэмт хэрэг үйлдсэний улмаас мөрдөн байцаагдаж байгаа ямар ч этгээд шүүн таслах аль ч шатанд түүнтэй шударга харьцах баталгаагаар хангагдана. Хүчээр алга болгох гэмт хэрэгт шүүн таслагдаж байгаа ямар ч этгээд эрх бүхий, хараат бус, шударга шүүх буюу хуулийн дагуу байгуулагдсан бусад шүүхээр хэргээ шударгаар шийдвэрлүүлэх эрхтэй.

### **12 дугаар зүйл**

1. Хүчээр алга болгох гэмт хэргийн улмаас хэн нэгнийг хохирогч болсон тухай нотолгоо гаргаж буй этгээд тухайн нотолгоог түргэн шуурхай,

шударгаар авч үзэх, шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаалтыг хойшлуулалгүй, нягт нямбай, шударга явуулах эрх бүхий байгууллагад холбогдох баримтыг өгөх эрхийг оролцогч улс бүр аль ч этгээдэд олгоно. Шаардлагатай тохиолдолд гомдол гаргагч, гэрч, алга болсон этгээдийн төрөл төрөгсөд, тэдний хамгаалагчид, түүнчлэн мөрдөн байцаалтад оролцож буй этгээдүүдийг гомдол гаргасан буюу мэдүүлэг өгснөөс үүдэж тэдэнтэй хууль бус хандах буюу сүрдүүлэхээс сэргийлж хамгаалахад шаардлагатай арга хэмжээ авна.

2. Аль ч тохиолдолд хэн нэгэн этгээдийг хүчээр алга болгосон гэж үзэх боломжит үндэслэл байвал энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан байгууллага албан ёсны гомдол гаргаагүй байсан ч мөрдөн байцаалтыг явуулна.

3. Оролцогч улс бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан байгууллагыг дараах боломжоор хангана:

(а) мөрдөн байцаалтыг үр дүнтэй явуулах, түүний дотор мөрдөн байцаалтад нь хамаарах бичиг баримт болон бусад мэдээлэлд хүрэхэд шаардлагатай эрх мэдэл, нөөц бололцоо олгох;

(б) шаардлагатай бол тухайн асуудлаар шуурхай шийдвэр гаргах шүүхийн эрх бүхий байгууллагаас урьдчилан авсан зөвшөөрөлтэйгөөр албадан саатуулсан газарт, эсхүл алга болсон этгээд байж болзошгүй гэж итгэх боломжит үндэслэл байгаа аливаа өөр газарт нэвтрэх боломж олгох.

4. Оролцогч улс бүр мөрдөн байцаалтыг явуулахад саад болж буй үйлдлээс урьдчилан сэргийлэх, тийм үйлдэлд шийтгэл ногдуулахад шаардлагатай арга хэмжээг авна. Тухайлбал, хүчээр алга болгох гэмт хэргийг үйлдсэн гэж сэжиглэгдэж буй этгээд гомдол гаргагч, гэрч, алга болсон этгээдийн төрөл садан буюу тэдний өмгөөлөгч, эсхүл мөрдөн байцаалтад оролцож буй этгээдүүдийг дарамтлах, эсхүл айлган сүрдүүлэх буюу мөрдөн мөшгих үйлдлийн аргаар мөрдөн байцаалтын явцад нөлөөлөх боломжгүй байх явдлыг тухайн улс хангана.

### **13 дугаар зүйл**

1. Оролцогч улсуудын хооронд гэмт этгээдийг шилжүүлэн өгөх зорилгоор, хүчээр алга болгох гэмт хэргийг улс төрийн гэмт хэрэг гэж, эсхүл улс төрийн гэмт хэрэгтэй холбоотой гэмт хэрэг гэж, эсхүл улс төрийн сэдэлтээр үйлдсэн гэмт хэрэг гэж үзэхгүй. Улмаар ийм гэмт хэрэгт үндэслэсэн шилжүүлэн авах тухай хүсэлтийг биелүүлэхээс зөвхөн эдгээр үндэслэлээр татгалзаж болохгүй.

2. Хүчээр алга болгох гэмт хэргийг энэхүү конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө оролцогч улсуудын хооронд байгуулсан гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээнд шилжүүлэн өгөх гэмт хэрэг хэмээн оруулсан гэж үзнэ.



3. Оролцогч улсууд хойшид хоорондоо байгуулах гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай аливаа гэрээндээ хүчээр алга болгох гэмт хэргийг шилжүүлэн өгөх гэмт хэрэг хэмээн оруулах үүрэг хүлээнэ.

4. Хэрэв гэмт этгээдийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаг оролцогч улс гэмт этгээд шилжүүлэн өгөх тухай гэрээ түүнтэй байгуулаагүй өөр нэг оролцогч улсаас гэмт этгээд шилжүүлэн өгөх тухай хүсэлт хүлээн авбал тухайн улс энэхүү конвенцыг хүчээр алга болгох гэмт хэргийн хувьд гэмт этгээдийг шилжүүлэн өгөх эрх зүйн шаардлагатай үндэс гэж үзэж болно.

5. Гэмт этгээдийг гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгөх нөхцөл тавьдаггүй оролцогч улсууд хүчээр алга болгох гэмт хэргийг шилжүүлэн өгөх гэмт хэрэг гэж өөр хоорондоо хүлээн зөвшөөрнө.

6. Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх нь бүх тохиолдолд хүсэлт хүлээн авагч оролцогч улсын хуулиар, эсхүл шилжүүлэн өгөх тухай холбогдох гэрээнд заасан нөхцөл, түүний дотор шилжүүлэн өгөхөд тавих ялын доод хэмжээний шаардлага болон хүсэлт хүлээн авагч оролцогч улс шилжүүлэн өгөхөөс татгалзаж буюу шилжүүлэн өгөхийг тодорхой нөхцөлийн дагуу хэрэгжүүлж болох үндэслэлд хамаарах нөхцөлийн дагуу хэрэгжинэ.

7. Хэрэв аливаа хүнийг түүний хүйс, арьс үндэс, шашин шүтлэг, иргэний харьяалал, удам угсаа, улс төрийн үзэл бодол буюу нийгмийн тодорхой нэг бүлгийн гишүүнчлэлийн үндэслэлээр, эсхүл тухайн хүсэлтийг биелүүлснээр эдгээр шалтгааны аль нэгийн улмаас тухайн хүнд гэм хор учруулна гэсэн үндэслэлээр мөрдөх, эсхүл шийтгэх зорилгоор хүсэлт гаргасан гэж итгэх ноцтой үндэслэл хүсэлт хүлээн авагч улсад байгаа бол энэхүү конвенцын аль ч заалтыг шилжүүлэн өгөх үүрэг хүлээлгэж буй гэж тайлбарлахгүй.

#### **14 дүгээр зүйл**

1. Оролцогч улсууд хүчээр алга болгох гэмт хэргийн талаар үүсгэсэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбогдуулан эрх зүйн харилцан туслалцааг өөр хоорондоо дээд зэргээр үзүүлнэ, түүний дотор байцаан шийтгэх ажиллагаанд шаардлагатай бөгөөд тэдний мэдэлд байгаа бүх нотлох баримтыг гаргана.

2. Ийнхүү үзүүлэх эрх зүйн харилцан туслалцаа нь хүсэлт хүлээн авагч оролцогч улсын дотоодын хууль, эсхүл эрх зүйн харилцан туслалцааны тухай холбогдох гэрээнд заасан нөхцөл, түүний дотор хүсэлт хүлээн авагч оролцогч улс эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхээс татгалзаж буюу эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэхийг тодорхой нөхцөлийн дагуу хэрэгжүүлж болох үндэслэлд хамаарах нөхцөлийн дагуу хэрэгжүүлнэ.

### **15 дугаар зүйл**

Оролцогч улсууд хүчээр алга болгох гэмт хэргийн хохирогчдод туслах, алга болсон хүнийг эрж хайх, байршлыг тогтоох болон суллах, түүнчлэн нас барсан тохиолдолд задлан шинжилж, таньж тогтоож, цогцсыг нь буцаах талаар бие биетэйгээ хамтран ажиллаж, эрх зүйн туслалцааг өөр хоорондоо дээд зэргээр үзүүлнэ.

### **16 дугаар зүйл**

1. Тухайн хүнийг хүчээр алга болгох аюул байна гэж үзэх ноцтой үндэслэл байгаа тохиолдолд оролцогч аль ч улс түүнийг өөр улсад цөлөх, буцаах, шилжүүлэх буюу шилжүүлэн өгөхгүй.

2. Тийм үндэслэл байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор эрх бүхий байгууллага холбогдох бүх хүчин зүйл, түүний дотор тухайн улсад хүний эрхийг байнга их хэмжээгээр, бүдүүлгээр, олныг хомроглон зөрчдөг, эсхүл олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтойгоор зөрчдөг байдлыг харгалзан үзнэ.

### **17 дугаар зүйл**

1. Хэнийг ч нууцаар албадан саатуулж болохгүй.

2. Эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой оролцогч тухайн улсын олон улсын бусад үүргийг хөндөхгүйгээр оролцогч улс бүр хууль тогтоомждоо:

(а) эрх чөлөөг хязгаарлах тушаал гаргаж болох нөхцөлийг тодорхойлно;

(b) эрх чөлөөг хязгаарлах тушаал гаргах эрх бүхий этгээдийг заана;

(c) эрх чөлөө нь хязгаарлагдсан аливаа хүнд гагцхүү эрх чөлөөг хязгаарлах албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд хяналтан доор байгаа газарт байна гэдэг баталгаа гаргана;

(d) эрх чөлөө нь хязгаарлагдсан аливаа хүнд гэр бүл, өмгөөлөгч буюу өөрийн сонгосон аливаа бусад этгээдтэй зөвхөн хуулиар тогтоосон нөхцөлийн дагуу харьцах, тэдэнтэй уулзах, эсхүл хэрэв тэрбээр гадаадын иргэн бол консулын эрх бүхий байгууллагатайгаа олон улсын эрх зүйн холбогдох хэм хэмжээний дагуу харьцахыг зөвшөөрөх баталгаа гаргана;

(e) эрх чөлөөг хязгаарлах газарт, хэрэв шаардлагатай бол шүүхийн эрх бүхий байгууллагын урьдчилан авсан зөвшөөрөлтэйгөөр, эрх бүхий бөгөөд хуулийн дагуу эрх олгогдсон байгууллага нэвтрэх баталгаа гаргана;

(f) эрх чөлөө нь хязгаарлагдсан аливаа хүн, эсхүл хүчээр алга болгосон гэж сэжиглэсэн тохиолдолд эрх чөлөө нь хязгаарлагдсан хүн





энэ эрхээ хэрэгжүүлэх боломжгүй тул эрх чөлөө нь хязгаарлагдсан хүний төрөл садан, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч зэрэг хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах аливаа хүнд шүүхэд хандах эрхийг бүх тохиолдолд олгох бөгөөд шүүх эрх чөлөөг нь хязгаарласан нь хууль ёсны гэдгийг нэн даруй шийдвэрлэх, хэрэв эрх чөлөөг нь хязгаарласан нь хууль бус бол тухайн хүнийг суллахыг тушааж болно.

3. Оролцогч улс бүр эрх чөлөө нь хязгаарлагдсан хүний албан ёсны болон цаг үеийн нэг буюу хэд хэдэн бүртгэл болон/эсхүл тэмдэглэл бүрдүүлэн хөтлөх явдлыг хангах бөгөөд уг бүртгэл болон/эсхүл тэмдэглэлийг оролцогч тухайн улсын хууль, эсхүл тухайн улс оролцогч нь болох олон улсын эрх зүйн холбогдох аливаа баримт бичгийн дагуу энэ зорилгоор эрх олгогдсон шүүхийн буюу эрх бүхий бусад байгууллагад хүсэлтээр нь шуурхай гаргаж өгнө. Уг мэдээлэлд наад зах нь дараах мэдээлэл хамаарна:

- (a) эрх чөлөө нь хязгаарлагдсан хүний биеийн байцаалт;
- (b) тухайн хүний эрх чөлөөг хязгаарласан он, сар, өдөр, цаг, газар болон эрх чөлөөг нь хязгаарласан эрх бүхий байгууллага;
- (c) эрх чөлөөг нь хязгаарлах тушаал гаргасан эрх бүхий байгууллага болон эрх чөлөөг нь хязгаарлах болсон үндэслэл;
- (d) эрх чөлөөг хязгаарлах явцын хяналтыг хариуцах эрх бүхий байгууллага;
- (e) эрх чөлөөг хязгаарласан газар, эрх чөлөөг хязгаарлахаар хүлээн авсан он, сар, өдөр, цаг, түүнчлэн эрх чөлөөг хязгаарлах газрыг хариуцах эрх бүхий байгууллага;
- (f) эрх чөлөө нь хязгаарлагдсан хүний эрүүл мэндийн байдалд хамаарах мэдээлэл;
- (g) эрх чөлөөг нь хязгаарласан үед нас барсан тохиолдолд нас барсан нөхцөл байдал, шалтгаан, цогцсыг илгээх газар;
- (h) Сулласан, эсхүл албадан саатуулах өөр газарт шилжүүлсэн он, сар, өдөр, цаг, шилжүүлэх газар болон хариуцах эрх бүхий байгууллага.

### **18 дугаар зүйл**

1. 19, 20 дугаар зүйлийг мөрдөхийн хамт, оролцогч улс бүр тухайн мэдээлэлд хууль ёсны ашиг сонирхол бүхий аливаа хүн, тухайлбал, эрх чөлөө нь хязгаарлагдсан хүний төрөл садан, тэдний төлөөлөгч буюу тэдний өмгөөлөгчид наад зах нь дараах мэдээлэлд хүрэх боломж олгох баталгаа гаргана:

- (a) эрх чөлөөг нь хязгаарлах тушаал гаргасан эрх бүхий байгууллага;
- (b) тухайн хүний эрх чөлөөг хязгаарлаж, эрх чөлөөг нь хязгаарлах газарт хүлээн авсан он, сар, өдөр, цаг, газар;
- (c) эрх чөлөөг нь хязгаарлах явцын хяналтыг хариуцах эрх бүхий байгууллага;

(d) эрх чөлөө нь хязгаарлагдсан хүний байгаа газар, түүний дотор эрх чөлөөг нь хязгаарлах өөр газарт шилжүүлэх тохиолдолд ийнхүү шилжүүлэх газар болон хариуцах эрх бүхий байгууллага;

(e) сулласан он, сар, өдөр, цаг, газар;

(f) эрх чөлөө нь хязгаарлагдсан хүний эрүүл мэндийн байдалд хамаарах мэдээлэл;

(g) эрх чөлөөг нь хязгаарласан үед нас барсан тохиолдолд нас барсан нөхцөл байдал, шалтгаан, цогцсыг илгээх газар.

2. Эрх чөлөө нь хязгаарлагдсан хүний талаар мэдээлэл авах эрлийн үр дүнд энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүн болон мөрдөн байцаалтад оролцож буй хүнтэй зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэх, эсхүл залхаан цээрлүүлэх үйлдлээс хамгаалах талаар шаардлагатай бол зохих арга хэмжээ авна.

### **19 дүгээр зүйл**

1. Алга болсон этгээдийг эрж хайх хүрээнд цуглуулсан болон/эсхүл дамжуулсан хувийн мэдээлэл, түүний дотор эмнэлгийн болон удамшлын мэдээ баримтыг алга болсон хүнийг эрж хайхаас өөр зорилгоор ашиглах буюу гаргаж өгөхгүй. Энэ нь уг мэдээллийг хүчээр алга болгох гэмт хэрэгт хамаарах эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд, эсхүл нөхөн төлбөр олж авах эрх хэрэгжүүлэхэд ашиглах явдлыг хөндөхгүй.

2. Хувийн мэдээлэл, түүний дотор эмнэлгийн болон удамшлын мэдээ баримт цуглуулах, боловсруулах, ашиглах болон хадгалах нь хүний эрх, үндсэн эрх чөлөө буюу хувь хүний нэр төр нандин чанарыг алдуулахгүй буюу алдагдахад хүргэх ёсгүй.

### **20 дугаар зүйл**

1. Аливаа хүн хуулийн хамгаалалтад байгаа бөгөөд эрх чөлөөг нь зөвхөн шүүхийн хяналтын доор хязгаарлаж буй тохиолдолд л 18 дугаар зүйлд дурдсан мэдээллийг авах эрхийг хязгаарлаж болох бөгөөд чингэхдээ үнэхээр шаардлагатай бөгөөд хуульд заасан онцгой тохиолдолд, түүнчлэн тухайн мэдээллийг дамжуулах нь тухайн хүний хувийн амьдрал буюу аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд саад учруулахаар байвал, эсхүл хуульд заасан аливаа бусад адилтгах шалтгаанаар олон улсын эрх зүйн холбогдох хэм хэмжээ болон энэхүү конвенцын зорилттой нийцүүлэн хязгаарлаж болно. Ямар ч тохиолдолд 18 дугаар зүйлд дурдсан мэдээллийг авах эрхийг 2 дугаар зүйлд тодорхойлсон үйлдэл болохуйцаар, эсхүл 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчихүйцээр хязгаарлаж үл болно.

2. Аливаа хүний эрх чөлөөг хязгаарласан нь хууль ёсны эсэх асуудлыг авч үзэхийг хөндөхгүйгээр оролцогч улсууд 18 дугаар зүйлийн



1 дэх хэсэгт дурдсан мэдээллийг сааталгүйгээр олж авах арга болгон шүүхийн хамгаалалтын арга хэмжээг шуурхай бөгөөд үр дүнтэйгээр авахуулах эрхийг 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүнд олгох баталгаа гаргана. Эрх зүйн хамгаалалтын арга хэмжээ авах энэ эрхийг ямар ч нөхцөл байдалд түдгэлзүүлж буюу хязгаарлаж болохгүй.

### **21 дүгээр зүйл**

Эрх чөлөө нь хязгаарлагдсан хүнийг үнэхээр сулласан гэж найдвартай нягтлан шалгах боломж бүхий байдлаар түүнийг суллах явдлыг хангах талаар оролцогч улс бүр шаардлагатай арга хэмжээ авна. Тухайн хүний биед үл халдах, түүнчлэн тухайн хүн суллагдах үедээ эрхээ бүрэн хэрэгжүүлэх чадвартай байх явдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээг оролцогч улс бүр тухайн хүний үндэсний хууль тогтоомжийн дагуу хүлээж болох аливаа үүргийг хөндөхгүйгээр мөн авна.

### **22 дугаар зүйл**

Оролцогч улс бүр дараах үйлдлээс урьдчилан сэргийлэх, дараах үйлдэлд шийтгэл ногдуулахад шаардлагатай арга хэмжээг 6 дугаар зүйлийг хөндөхгүйгээр авна:

(а) 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн (f) дэд хэсэг болон 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрх зүйн хамгаалалтын арга хэрэглэхийг саатуулах буюу хэрэглэхэд саад болох;

(b) аливаа хүний эрх чөлөөг хязгаарласан тухай бүртгэхгүй байх, эсхүл албан ёсны бүртгэл хариуцаж буй албан тушаалтан тухайн мэдээллийг буруу гэдгийг мэдсээр байж, эсхүл буруу гэдгийг мэдэх ёстой байсан атлаа бүртгэх;

с) иргэний эрх чөлөөг хассан буюу холбогдолгүй мэдээллээр тийм мэдээллээр хангах эрх зүйн шаардлагыг биелүүлсэн ч гэсэн хангахаас татгалзах.

### **23 дугаар зүйл**

1. Оролцогч улс бүр эрх чөлөөгөө хасуулсан аливаа хүнийг албадан саатуулах, эсхүл түүнтэй харилцаж болох, хууль хэрэгжүүлэх ажил эрхэлсэн цэргийн болон иргэний, эсхүл, эмнэлгийн ажилтан, төрийн албан хаагчдын сургалтад дараах үйл ажиллагааг явуулахын тулд энэхүү конвенцын зохих заалтуудтай холбоотой боловсрол, мэдээллийг оруулах нөхцөлийг хангана:

(а) хүчээр алга болгоход тухайн албан тушаалтан оролцохоос урьдчилан сэргийлэх;

(b) хүчээр алга болгохоос урьдчилан сэргийлэх болон мөрдөн байцаалтын чухлыг анхааралдаа авах;

(с) хүчээр алга болгох тохиолдолтой холбогдсон хэргүүдийг нэн яаралтай шийдвэрлэх шаардлагыг хүлээн зөвшөөрөх нөхцөлөөр хангах.

2. Оролцогч улс бүр хүчээр алга болгохыг хориглосон тухай зааварласан, зөвшөөрсөн, эсхүл дэмжсэн шийдвэр буюу заавраар хангана. Оролцогч улс бүр ийм шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан хүнийг шийтгэхгүй байх баталгааг гаргана.

3. Оролцогч улс бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүчээр алга болгох гэмт хэрэг гарсан буюу төлөвлөгдөж байсанд итгэх шалтгаан байгаа хүн нь өөрийн ахлах албан тушаалтанд шаардлагатай бол зохих байгууллага, эсхүл нягтлан шалгах эрхтэй хүнд гэмт хэргийн талаар илтгэх нөхцөлийг хангахад шаардлагатай арга хэмжээ авна.

### **24 дүгээр зүйл**

1. Энэхүү конвенцын зорилгоор “хохирогч” гэж алга болсон хүн болон хүчээр алга болгох үйлдлийн шууд нөлөөгөөр хохирогч болсон аливаа хувь этгээдийг хэлнэ.

2. Хохирогч бүр хүчээр алга болгох нөхцөл байдал, мөрдөн байцаалтын үйл явц, үр дүн болон алга болсон хүнтэй холбоотой үнэнийг мэдэх эрхтэй. Оролцогч улс бүр үүнтэй холбогдсон зохих арга хэмжээг авна.

3. Оролцогч улс бүр алга болсон хүнийг эрэн сурвалжлах, байршлыг нь тогтоох, суллах, амь үрэгдсэн тохиолдолд байршлыг нь тогтоох, цогцсыг нь хүндэтгэлтэйгээр буцаахтай холбогдсон арга хэмжээг авна.

4. Оролцогч улс бүр өөрийн эрх зүйн тогтолцоонд хүчээр алга бологсдын хохирогчдыг нөхөн төлбөрөө хурдан шуурхай, тэгш, хүрэлцэхүйц хэмжээгээр авах эрхээр хангана.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан нөхөн төлбөр авах эрх нь материалын болон оюун санааны хохирол, түүнчлэн шаардлагатай тохиолдолд нөхөн төлбөрийн дараах бусад хэлбэрийг хамаарна:

- (a) анхны эрхийг нь сэргээх;
- (b) алдагдсан эрхийг нөхөн сэргээх;
- (c) сэтгэл ханамжтай байдал болон нэр төрийг нь сэргээх;
- (d) дахин давтагдахгүй байх баталгаа гаргах.

6. Алга болсон хүний хувь заяаг тодруулж дуустал хийх мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэхэд саад учруулахгүйгээр, оролцогч улс бүр нийгмийн хамгаалал, санхүүгийн асуудал, гэр бүлийн тухай хууль болон өмчийн эрхийн салбаруудад хувь заяа нь хараахан тогтоогдоогүй алга



болсон хүмүүсийн болон тэдний хамаатан садангуудын эрх зүйн нөхцөл байдалтай холбогдуулан зохих арга хэмжээг авна.

7. Оролцогч улс бүр хүчээр алга болгох нөхцөл байдал, алга болсон хүний хувь заяаг тогтоохыг оролдож буй болон хүчээр алга болгосны улмаас хохирсон хүмүүст туслалцаа үзүүлэхтэй холбоотой байгууллага, нийгэмлэгийг чөлөөтэй байгуулах, оролцох эрхийн баталгаа гаргана.

### **25 дугаар зүйл**

1. Оролцогч улс бүр өөрийн эрүүгийн хуулийн дагуу дараах үйлдлээс урьдчилан сэргийлэх болон таслан зогсооход шаардлагатай арга хэмжээг авна:

(а) хүчээр алга болгохын золиос болж буй хүүхэд, эцэг, эх болон хууль ёсны асран халамжлагчийг хүчээр алга болгосны золиос болсон хүүхэд, эсхүл хүчээр алга болгохын золиос болсон эхийг нь олзлох үед төрсөн хүүхдийг хууль бусаар нүүлгэн шилжүүлэх;

(б) дээр дурдсан (а) дэд хэсэгт заасан хүүхдийн талаарх үнэн зөв тодорхойлолтыг гэрчлэхэд шаардлагатай баримт бичгүүдийг хуурамчаар үйлдэх, нуух, эсхүл устгах.

2. Оролцогч улс бүр энэ зүйлийн 1 (а) хэсэгт заасан хүүхдийг эрэн сурвалжлах, таньж тогтоох болон хэрэглэж болох олон улсын хэлэлцээр, эрх зүйн журмын дагуу тэдний төрөлх гэр бүлд тэднийг буцаах талаар шаардлагатай арга хэмжээг авна.

3. Оролцогч улсууд энэ зүйлийн 1 (а) хэсэгт заасан хүүхдийг эрэн сурвалжлах, таньж тогтоох болон байршлыг тодорхойлох талаар өөр хоорондоо туслалцаа үзүүлнэ.

4. Энэ зүйлийн 1 (а) хэсэгт дурдсан хүүхдийн ашиг сонирхлыг дээд зэргээр хангах шаардлагыг бодолцон, иргэний харьяалал, тэдгээрийн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн гэр бүлийн байдал, хэлхээ холбоо зэрэг өөрсдийгөө тодорхойлох эрхийг хамгаалах шаардлагын дагуу хүүхдийг үрчлэх тогтолцоо буюу асрамжид авах бусад хэлбэрийг хүлээн зөвшөөрдөг оролцогч улсууд хүчээр алга болгосны дүнд хүүхэд үрчлэх буюу асрамжид авах тухай журмыг дахин авч үзэх, хүүхдийг үрчлэх буюу асрамжид авах тухай хуулийн аливаа заалтыг шаардлагатай үед хүчингүй болгох эрх зүйн арга хэмжээ авна.

5. Аль ч тохиолдол, ялангуяа энэ зүйлтэй холбоотой асуудалд хүүхдийн ашиг сонирхлыг дээд зэргээр хангах шаардлагыг эн тэргүүнд тусгайлан авч үзэх ёстой бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх чадвартай хүүхдийн нас болон насанд хүрсэн байдлаас шалтгаалан хүүхэд нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байна.

## II ХЭСЭГ

### 26 дугаар зүйл

1. Энэхүү конвенцын заалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Хүчээр алга бологсдын асуудал эрхэлсэн хороо (цаашид “Хороо”)-г байгуулж байгаа бөгөөд Хороо нь өндөр ёс суртахуунтай, өөрсдийн хувийн чадвар болон бие даан, шударгаар үйл ажиллагаа явуулах, хүний эрхийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий арван шинжээчээс бүрдэнэ. Хорооны гишүүдийг оролцогч улсууд газар зүйн тэгш хуваарилалтын зарчмын дагуу сонгох бөгөөд Хорооны ажилд оролцогчдын хууль зүйн ажлын туршлага, хүйсийн тэнцвэртэй төлөөллийг харгалзан үзнэ.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаас хоёр жилд нэг удаа зарлан хуралдуулах оролцогч улсуудын хуралдаанаар оролцогч улсуудаас нэр дэвшүүлсэн харьяат иргэдийн жагсаалтаас нууц санал хураалтаар Хорооны гишүүдийг сонгоно. Оролцогч улсуудын гуравны хоёр нь энэ хуралдаанд оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцох бөгөөд Хорооны гишүүнээр сонгогдсон этгээд нь санал хураалтад оролцсон оролцогч улсуудын төлөөлөгчдийн олонхын болон дийлэнх олонхын саналыг авсан байна.

3. Эхний сонгуулийг энэхүү конвенцыг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сараас доошгүй хугацаанд хийнэ. Сонгууль болох өдрөөс дөрвөн сарын өмнө Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга гурван сарын дотор нэр дэвшигчдийг ирүүлэхийг урьсан тухай захидлыг оролцогч улсуудад хүргүүлнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга оролцогч улсаас нэр дэвшүүлсэн бүх хүний нэрсийн жагсаалтыг цагаан толгойн үсгийн дарааллаар бэлтгэж, энэ жагсаалтыг оролцогч бүх улсад хүргүүлнэ.

4. Хорооны гишүүдийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Тэд нэг удаа дахин сонгогдох эрхтэй. Гэхдээ эхний удаа сонгогдсон нийт гишүүнээс таван гишүүний мандат нь хоёр жилийн дараа дуусгавар болох бөгөөд эхний сонгуулийн дараа эдгээр таван гишүүний нэрийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуралдааныг даргалагч шодох хэлбэрээр тодруулна.

5. Хэрэв Хорооны гишүүн нь нас барсан буюу бүрэн эрхээсээ татгалзсан, эсхүл бусад шалтгаанаар өөрийн үүргээ цаашид биелүүлж чадахгүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шалгуурын дагуу түүнийг нэр дэвшүүлсэн оролцогч улс өмнөх гишүүний хугацаанд үүрэг гүйцэтгэх өөрийн улсын харьяат өөр нэр дэвшигчийг оролцогч улсуудын олонхоор батлуулах зорилгоор томилно. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаас санал болгосон томилгооны тухай мэдэгдсэнээс хойш зургаан долоо хоногийн дотор оролцогч улсуудын тал нь буюу



талаас дээш хувь нь эсрэг хариу өгөөгүй бол тийнхүү батлах асуудлыг авч хэлэлцэнэ.

6. Хороо нь өөрийн журмыг батална.

7. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Хороог чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэгсэл, боловсон хүчин, тоног төхөөрөмжөөр хангана. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Хорооны анхны хуралдааныг зарлан хуралдуулна.

8. Хорооны гишүүд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрх ямба, дархан эрхийн тухай конвенцын холбогдох хэсгүүдэд дурдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын төлөөлөгчийн газрын шинжээчдийн хөнгөлөлт, эрх ямба, дархан эрхийг эдэлнэ.

9. Оролцогч улс бүр Хороотой хамтран ажиллах, тэдгээрээс хүлээн зөвшөөрсөн Хорооны чиг үүргийн хүрээнд өөрийн гишүүний мандатыг биелүүлэхэд туслалцаа үзүүлнэ.

### **27 дугаар зүйл**

Энэхүү конвенцыг хүчин төгөлдөр болсноос хойш наад зах нь дөрвөн жил, цаад тал нь зургаан жилийн хугацаанд Хорооны үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тодорхойлсон журмын дагуу ямар нэгэн боломжийг хязгаарлахгүйгээр 28-36 дугаар зүйлд заасан үүргийн дагуу энэхүү конвенцын хяналтыг өөр этгээдэд шилжүүлэх нь зохимжтой эсэхийг шийдвэрлэх оролцогч улсуудын бага хурлыг хийнэ.

### **28 дугаар зүйл**

1. Энэхүү конвенцоор олгосон эрх хэмжээний хүрээнд Хороо нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн бүх байгууллага, албан газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын тусгай журмын дагуу олон улсын баримт бичигт үндэслэн байгуулагдсан гэрээт байгууллага, бүс нутгийн засгийн газар хоорондын байгууллага буюу этгээд, түүнчлэн хүчээр алга болгохын эсрэг бүх хүнийг хамгаалахад чиглэгдэн ажиллаж буй улсын бүх институт, агентлаг буюу албан газартай хамтран ажиллана.

2. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх үүднээс Хороо нь олон улсын хүний эрхийн баримт бичгийн дагуу байгуулагдсан бусад гэрээт байгууллага, тухайлбал Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын дагуу байгуулагдсан Хүний эрхийн хороотой тэдгээрийн холбогдох санамж болон зөвлөмжтэй нийцүүлэх зорилгоор харилцан зөвлөлдөнө.

### **29 дүгээр зүйл**

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд авсан арга хэмжээний тухай илтгэлийг холбогдох оролцогч

улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан Хороонд хүргүүлнэ.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга уг илтгэлийг оролцогч бүх улсад нээлттэй байх боломжоор хангана.

3. Хороо нь илтгэл бүрийг авч хэлэлцэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл тайлбар, санамж, эсхүл зөвлөмж гаргана.

4. Хороо нь энэхүү конвенцын хэрэгжилтийн тухай нэмэлт мэдээллээр хангахыг оролцогч улсуудаас шаардаж болно.

### **30 дугаар зүйл**

1. Алга болсон хүний хамаатан садан, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, зөвлөх буюу тэднээс эрх олгогдсон аливаа этгээд, түүнчлэн хууль ёсны ашиг сонирхолтой бусад этгээд алга болсон хүнийг эрэн сурвалжлах болон олох ёстой гэсэн хүсэлтийг Хороонд яаралтай тавьж болно.

2. Хэрэв Хороо нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу яаралтай арга хэмжээ авах тухай хүсэлтийг:

(а) ямар ч илт үндэслэлгүй;

(б) тухайн хүсэлт гаргах эрхийг урвуулан ашиглаагүй;

(с) оролцогч холбогдох улсын эрх бүхий байгууллага, тухайлбал мөрдөн байцаалт явуулах эрх бүхий байгууллагад гаргах боломж байсаар байтал түүнийг гаргаагүй;

(d) энэхүү конвенцын заалтуудтай нийцэхгүй байгаа;

(е) олон улсын мөрдөн байцаах, зохицуулах ижил төстэй журмын дагуу шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл

Хороо нь тогтоосон хугацаанд эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн нөхцөл байдлын талаарх мэдээллээр хангахыг оролцогч холбогдох улсаас хүснэ.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу оролцогч холбогдох улсаас өгсөн мэдээлэлд үндэслэн Хороо нь зөвлөмж, түүний дотор энэхүү конвенцын дагуу эрэн сурвалжлагдаж буй хүнийг олж тогтоох болон хамгаалах талаар авах түр зуурын арга хэмжээг оролцуулан зайлшгүй авах бүх арга хэмжээ, Хорооноос тогтоосон хугацаа болон нөхцөл байдлын хойшлуулшгүй чухлыг харгалзан тэдгээрээс авсан арга хэмжээний талаар Хороонд эргэж мэдээлэхийг хүссэн зөвлөмжийг оролцогч тухайн улсад хүргүүлж болно. Хороо нь өөрийн гаргасан зөвлөмжийн талаар болон хэрэв боломжтой бол оролцогч улсаас ирүүлсэн мэдээллийн талаар яаралтай арга хэмжээ авах талаар хүсэлт гаргасан этгээдэд мэдээлнэ.





4. Хороо нь эрэн сурвалжлагдаж буй хүний хувь заяа шийдэгдтэл оролцогч холбогдох улстай явуулах хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх талаар хүчин чармайлт гаргана. Хороо нь энэ талаар хүсэлт гаргагч этгээдэд мөн мэдээлнэ.

### **31 дүгээр зүйл**

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцыг соёрхон батлах, эсхүл түүний дараа ямар ч үед конвенцын заалтуудыг оролцогч тухайн улс зөрчсөнөөр түүний хохирогч болсон өөрийн хэргийн харьяаллын дагуу гомдол гаргах хувь этгээдээс буюу түүний нэрийн өмнөөс мэдээллийг хүлээн авах болон авч хэлэлцэх тухай Хорооны эрхийг хүлээн зөвшөөрөхөө мэдэгдэж болно. Хороо нь уг мэдэгдлийг хийгээгүй оролцогч улстай холбоотой мэдээллийг хүлээн авахгүй.

2. Хороо нь дараах төрлийн мэдээллийг хүлээж авахгүй:

(a) мэдээлэл нь нэрээ нууцалсан;

(b) мэдээлэл хүргүүлэх эрхийг урвуугаар ашигласан, эсхүл энэхүү конвенцын заалтуудтай тухайн мэдээлэл нийцээгүй;

(c) олон улсын мөрдөн байцаах, зохицуулах ижил төстэй журмын дагуу тухайн мэдээлэл нь шалгагдахаар; эсхүл

(d) уг мэдээлэл нь дотоодын эрх зүйн үр дүнтэй бүх арга хэрэгслийн талаар бүрэн дүүрэн тусгаагүй бол. Гэхдээ тухайн арга хэрэгслийг ашиглах явдлыг үндэслэлгүйгээр удаашруулахаар бол энэ журмыг хэрэглэхгүй.

3. Хэрэв Хороо нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагад мэдээлэл нийцэж байна гэж үзвэл Хорооноос тогтоосон хугацаанд санамж болон тайлбар ирүүлэх талаар хүсэлт гаргаж, оролцогч холбогдох улсад мэдээллийг хүргүүлнэ.

4. Мэдээллийг хүлээн авсны дараа зохих тодорхойлолт гаргахын өмнө Хороо нь сэжиг бүхий зөрчлийн улмаас хохирогчид засаршгүй хохирол учрах боломжоос зайлсхийхэд шаардлагатай байж болох түр зуурын арга хэмжээг оролцогч улсаас нэн даруй авахуулах зорилгоор оролцогч холбогдох улсад аль ч үед хүсэлт гаргаж болно. Уг боломжийг Хорооноос ашиглах нь мэдээллийг хүлээж авах эсэх, эсхүл бүхлээр нь авч хэлэлцэх эсэх асуудлыг урьдчилж шийдвэрлэхгүй.

5. Хороо нь энэ зүйлд заасан мэдээллийг хаалттай хуралдаанаар авч хэлэлцэнэ. Хороо нь оролцогч холбогдох улсаас ирүүлсэн хариултын талаар мэдээллийг зохиогчид мэдээлнэ. Хороо нь үйл ажиллагаагаа дуусгах тухай шийдвэр гаргамагц өөрийн хийсэн дүгнэлтийн талаар оролцогч улс болон мэдээллийг зохиогчид мэдэгдэнэ.

### **32 дугаар зүйл**

Энэхүү конвенцын оролцогч аль ч улс нь энэхүү конвенцын дагуу өөрийн хүлээсэн үүргийг оролцогч нөгөө улс биелүүлээгүй гэдгийг

оролцогч аль нэг улс нотолж хийсэн мэдээллийг Хороо нь хүлээн авч, хэлэлцэх чиг үүрэгтэй гэдгийг тэрээр хүлээн зөвшөөрч байгаагаа хэдийд ч мэдэгдэж болно. Хороо нь тийм мэдэгдэл хийгээгүй оролцогч холбогдох улсын ямар ч мэдээлэл болон тийм мэдэгдэл хийгээгүй оролцогч аль ч улсаас мэдээллийг хүлээн авахгүй.

### **33 дугаар зүйл**

1.Хэрэв, энэхүү конвенцын заалтуудыг оролцогч аль нэг улс ноцтойгоор зөрчиж байж болзошгүйг нотолсон мэдээллийг Хороо хүлээн авбал, тэрээр оролцогч холбогдох улстай зөвлөлдсөний дараагаар оролцогч тухайн улсад хүрэлцэн очиж, нэн даруй илтгэх үүргийн талаар өөрийн гишүүдийн нэгэнд нь, эсхүл хэд хэдэд нь хүсэлт гаргаж болно.

2.Хороо нь төлөөлөгчдийн бүрэлдэхүүн, айлчлалын зорилгыг тусгасан айлчлал хийх гэж байгаа өөрийн чиг санааны талаар оролцогч холбогдох улсад бичгээр мэдэгдэнэ Оролцогч тухайн улс боломжит хугацаанд Хороонд хариу өгнө.

3.Оролцогч тухайн улсын баримтаар нотолсон хүсэлтийн дагуу Хороо нь айлчлалыг хойшлуулах, эсхүл цуцлах тухай шийдвэр гаргаж болно.

4.Хэрэв оролцогч улс тийнхүү айлчлахыг зөвшөөрвөл, Хороо болон оролцогч тухайн улс айлчлал хийх нөхцөлийг тодорхойлох зорилгоор хамтран ажиллах бөгөөд оролцогч тухайн улс айлчлалыг амжилттай хийлгэх бүхий л боломжоор Хороог хангана.

5.Айлчлалын дараагаар Хороо өөрийн дүгнэлт, зөвлөмжийг холбогдох оролцогч тухайн улсад хүргүүлнэ.

### **34 дүгээр зүйл**

Аль нэг оролцогч улсын хэргийн харьяалалд байдаг нутаг дэвсгэрт хүчээр алга болгох явдал өргөн хэмжээгээр, эсхүл системтэйгээр хэрэгжиж байгаа тухай үндэслэлтэйгээр нотлогдсон мэдээлэл Хороо хүлээн авбал, холбогдох оролцогч тухайн улсаас нөхцөл байдлын талаар зохих бүхий л мэдээллийг урьдчилж авсны дараагаар асуудлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан Ерөнхий Ассамблейн анхааралд яаралтай хандуулна.

### **35 дугаар зүйл**

1.Хорооны эрх мэдэл зөвхөн энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа бий болох хүчээр алга болгох асуудлыг хамаарна.

2.Энэхүү конвенцыг хүчин төгөлдөр болсноос хойш аль нэг улс түүний оролцогч болбол тухайн улсын Хорооны хувьд хүлээх үүрэг нь



энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа бий болох хүчээр алга болгох тохиолдлыг л зөвхөн хамаарна.

### **36 дугаар зүйл**

1.Хороо энэхүү конвенцыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх өөрийн илтгэлийг оролцогч улсууд болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейд жил бүр хүргүүлж байна.

2.Жил бүрийн илтгэлд аль нэг оролцогч улсын талаарх дүгнэлтийг тусгахын өмнө оролцогч тухайн улсад урьдчилан мэдэгдэж, тухайн улсаас хариулт өгөх боломжит хугацаагаар хангана. Жил бүрийн илтгэлд оролцогч тухайн улс өөрийн тайлбар, дүгнэлтийг нийтлүүлэх талаар хүсэлт гаргаж болно.

## **III ХЭСЭГ**

### **37 дугаар зүйл**

Энэхүү конвенцын аль ч заалт нь хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах талаар илүү үр дүн үзүүлж болох дараах хуулийн аливаа заалтад нөлөөлөхгүй:

- (а) оролцогч улсын хууль тогтоомж дахь;
- (б) тухайн улсын хувьд хүчин төгөлдөр олон улсын эрх зүй дэх.

### **38 дугаар зүйл**

1.Энэхүү конвенц нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

2.Энэхүү конвенцыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улс соёрхон батална. Соёрхон баталсан тухай батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3.Энэхүү конвенц Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улс нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаар нэгдэн орох явдал хүчин төгөлдөр болно.

### **39 дүгээр зүйл**

1.Энэхүү конвенц нь хорь дахь соёрхон баталсан батламж жуух бичиг, эсхүл түүнд нэгдэн орсон баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно.

2. Хорь дахь соёрхон батласан батламж жуух бичиг, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш энэхүү конвенцыг соёрхон баталж буй, эсхүл нэгдэн орж буй улсын хувьд соёрхон баталсан батламж жуух бичиг, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгээ

хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш гуч дахь өдөр энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болно.

#### **40 дүгээр зүйл**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бүх улс болон энэхүү конвенцод гарын үсэг зурсан буюу нэгдэн орсон бүх улсад дараах зүйлийг мэдэгдэнэ:

(а) 38 дугаар зүйлийн дагуу гарын үсэг зурсан, соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай;

(б) 39 дүгээр зүйлийн дагуу энэхүү конвенцын хүчин төгөлдөр болсон өдрийн тухай.

#### **41 дүгээр зүйл**

Энэхүү конвенцын заалтуудыг холбооны улсуудын бүх хэсэгт ямар нэг хязгаарлалт, эсхүл онцгойлон үзэлгүйгээр хэрэглэнэ.

#### **42 дугаар зүйл**

1.Энэхүү конвенцыг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдон хоёр буюу хэд хэдэн оролцогч улсын хооронд гарсан маргааныг хэлэлцээний замаар, эсхүл энэхүү конвенцод шууд тусгасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй бол тухайн маргаанд оролцогч аль нэг талын хүсэлтээр түүнийг арбитрын шүүхэд шилжүүлнэ. Арбитрын шүүхэд шилжүүлсэн өдрөөс хойш зургаан сарын хугацаанд талууд арбитрын шүүхийг зохион байгуулах талаар тохиролцоонд хүрч чадаагүй бол тухайн талуудын аль нэгний хүсэлтээр маргааныг Олон улсын шүүхэд түүний дүрмийн дагуу хэлэлцүүлэхээр шилжүүлж болно.

2.Аль нэг улс энэхүү конвенцод гарын үсэг зурах, соёрхон батлах, эсхүл нэгдэн орох үедээ энэ зүйлийн 1 дэх заалтыг заавал биелүүлэхгүй байх талаар мэдэгдэл хийж болно. Оролцогч бусад улс ийм мэдэгдэл хийсэн оролцогч улсын хувьд энэ зүйлийн 1 дэх заалтыг заавал биелүүлэх албагүй.

3.Энэ зүйлийн 2 дахь заалтын дагуу мэдэгдэл хийсэн оролцогч аль ч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэн мэдэгдлээ хэдийд ч буцаан авч болно.

#### **43 дугаар зүйл**

Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, тэр дундаа 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн дөрвөн конвенц болон түүний 1977 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн Нэмэлт хоёр протоколоор хэлэлцэн тохирогч талуудын хүлээсэн үүрэг, эсхүл оролцогч аливаа улсын боломж бололцоонд ямар нэг хохирол учруулахгүйгээр олон улсын хүмүүнлэгийн эрх зүйгээр



зохицуулагдаагүй нөхцөлд Олон улсын Улаан загалмай нийгэмлэгээс хорих газруудад энэхүү конвенцын дагуу хүрэлцэн очихыг зөвшөөрнө.

#### **44 дүгээр зүйл**

1. Энэхүү конвенцод оролцогч аливаа улс түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болох бөгөөд саналаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга санал болгосон нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн, санал хураах зорилгоор оролцогч улсуудын бага хурал хуралдуулах эсэх талаар энэхүү конвенцын оролцогч улсуудад уламжилна. Ийнхүү уламжилсан өдрөөс хойш дөрвөн сарын хугацаанд оролцогч улсуудын наад зах нь гуравны нэг нь ийм бага хурал хуралдуулахыг дэмжвэл Ерөнхий нарийн бичгийн дарга бага хурлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээл дор зарлан хуралдуулна.

2. Бага хуралд байлцаж санал өгсөн оролцогч улсуудын гуравны хоёрын олонхын саналаар батласан аливаа нэмэлт, өөрчлөлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга оролцогч бүх улсуудад хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор тараана.

3. Энэ зүйлийн 1 дэх заалтын дагуу батлагдсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү конвенцод оролцогч улсуудын гуравны хоёр нь өөр өөрсдийн үндсэн хуулийн журмын дагуу баталснаар хүчин төгөлдөр болно.

4. Хүчин төгөлдөр болж буй аливаа нэмэлт, өөрчлөлт нь тухайн нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн оролцогч улсуудын хувьд заавал биелүүлэх ёстой бөгөөд оролцогч бусад улсын хувьд энэхүү конвенцын заалтууд болон тэдгээрийн өмнө нь хүлээн зөвшөөрсөн аливаа нэмэлт, өөрчлөлтийг заавал биелүүлэх ёстой.

#### **45 дугаар зүйл**

1. Энэхүү конвенцын англи, араб, испани, орос, хятад, франц хэлээрх эх бичвэрүүд адил хүчинтэй бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хадгална.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү конвенцын баталгаат хуулбарыг 38 дугаар зүйлд дурдсан бүх улсад тараана.

#### **Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 200003